



ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 06 сарын 05 өдөр

Дугаар А/195

Улаанбаатар хот

Журам батлах тухай


Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4, Ахмад настны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6, 9 дүгээр зүйлийн 9.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Гамшгаас хамгаалах эрх зүйн орчинг боловсронгуй болгох, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх ахмад настны "Зөвлөх мэргэжилтний багийн ажиллах журам"-ыг хавсралтаар баталсугай.

2. Зөвлөх мэргэжилтний багийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллахыг Онцгой байдлын ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга нар, төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга, захирагч нарт тус тус үүрэг болгосугай.


3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тэргүүн дэд дарга (бригадын генерал Г.Ариунбуян)-д даалгасугай.

ДАРГА,  
ХОШУУЧ ГЕНЕРАЛ



Т.БАДРАЛ

Онцгой байдлын ерөнхий газрын даргын  
2018 оны 06 дугаар сарын 05 ны өдрийн  
А/195 дугаар тушаалын хавсралт



## ЗӨВЛӨХ МЭРГЭЖИЛТНИЙ БАГИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

*Нэг. Нийтлэг үндэслэл*

1.1. Энэхүү журам нь гамшгаас хамгаалах эрх зүйн орчинг боловсронгуй болгох, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх Зөвлөх мэргэжилтний баг /цаашид “Баг” гэх/-ийн бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааны үндсэн чиглэл, санхүүжилттэй холбоотой харилцааг зохицуулна.

1.2. Багийн үйл ажиллагааны эрх зүйн үндэс нь Гамшгаас хамгаалах тухай, Ахмад настны тухай, Хөдөлмөрийн тухай хууль болон Онцгой байдлын байгууллагад мөрдөгдөж буй бусад хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээний акт байна.

1.3. Энэхүү журмын зорилго Онцгой байдлын албанд ажилласан ахмадуудын мэдлэг, мэргэжлийн ур чадварын баялаг туршлагыг залуу үедээ залгамжлуулан үлдээх, Онцгой байдлын албаны үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд оршино.

*Хоёр. Зөвлөх мэргэжилтний багийн бүтэц, удирдлага, зохион байгуулалт.*

2.1. Багийн үйл ажиллагааг Онцгой байдлын ерөнхий газрын тэргүүн дэд дарга нэгдсэн удирдлагаар хангаж, өдөр тутмын үйл ажиллагааг Зөвлөх мэргэжилтний багийн ахлагч удирдана.

2.2. Баг нь ахлагч, гишүүд, нарийн бичгийн дарга гэсэн 13 хүртэл хүний бүрэлдэхүүнтэй байна.

2.3. Онцгой байдлын албанд олон жил, үр бүтээлтэй ажилласан, зохих мэдлэг боловсрол, ур чадвар, дадлага туршлагатай алба хаагчдын бүртгэл, тэдний бүтээлийн судалгаа хийж, Багт шаардлагатай үед ажиллуулах зорилгоор зөвлөх мэргэжилтний нөөцийн мэдээллийн санг Захиргааны удирдлагын газар, Ахмадын хороо хамтран бүрдүүлнэ. Зөвлөх мэргэжилтний мэдээллийн сангийн баяжилтыг жил бүрийн 3, 9 дүгээр сард хийнэ.

2.4. Ахмадын хорооны удирдах зөвлөлийн хурлаар Багийн бүрэлдэхүүн болон нөхөн сонгогдох мэргэжилтнүүдийг сонгон шалгаруулахдаа мэдээллийн санд бүртгэлтэй ахмадуудаас ажлын дадлага, туршлага, мэргэжлийн ур чадвар, эрүүл мэндийг нь харгалзан нэр дэвшүүлж, хэлэлцэн олонхийн санал авсан ахмадыг тоо хязгаарлахгүйгээр сонгоно.

2.5. Багийн бүрэлдэхүүнд нэр дэвшсэн ахмадаас Онцгой байдлын ерөнхий газрын даргын зөвлөл багийн ахлагч, нарийн бичгийн дарга, бүрэлдэхүүнийг сонгон Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаалаар томилно.

2.6. Ажлын шаардлага, үүссэн нөхцөл байдлаас шалтгаалан Багийн үйл ажиллагаанд мэдээллийн санд бүртгэлтэй ахмадуудыг татан оролцуулж болно.

2.7. Багийн ахлагч, нарийн бичгийн дарга, гишүүд ямар нэг шалтгаанаар чөлөөлөгдсөн тохиолдолд энэхүү журмын 2.5-д заасан зөвлөх мэргэжилтний нөөцөөс нөхөн бүрдүүлнэ.

*Гурав. Зөвлөх мэргэжилтний багийн үйл ажиллагааны чиглэл.*

3.1. Баг нь ажлаа Онцгой байдлын байгууллагын үйл ажиллагааны жилийн болон дунд хугацааны стратеги төлөвлөгөөтэй уялдуулан жилээр төлөвлөж, Онцгой байдлын ерөнхий газрын тэргүүн дэд даргаар батлуулж, мөрдөнө.

3.2. Зөвлөх мэргэжилтнүүд төв, орон нутагт ажиллах удирдамжийг Онцгой байдлын ерөнхий газрын даргаар батлуулж, ажлын үр дүнг Багийн хурлаар хэлэлцэн нэгтгэж, санал, зөвлөмжөө тэргүүн дэд даргаар уламжлан Онцгой байдлын ерөнхий газрын даргад танилцуулна.

3.3. Баг дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулна. Үүнд:

3.3.1. Онцгой байдлын албаны эрх зүйн орчныг боловсронгуй болгох, бодлогын чанартай баримт бичиг боловсруулах, судалгаа, шинжилгээний ажлыг зохион байгуулахад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх,

3.3.2. Гамшгаас хамгаалах талаар батлагдсан хууль тогтоомж, төрөөс баримтлах бодлого, хөтөлбөр, Монгол Улсын Шадар сайд, Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаал, шийдвэр, удирдлагын бусад баримт бичгийг хэрэгжүүлэхэд Онцгой байдлын байгууллагад санал, зөвлөмж өгөх, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх,

3.3.3. Улс орны хэмжээнд тохиолдсон гамшиг ослын дараа судалгаа хийж, дүгнэлт, зөвлөмж гаргах, гамшгийн эрсдэлийн тойм судалгаа хийх ажилд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх,

3.3.4. Гамшгаас хамгаалах сургалт, сурталчилгааны ажил, эрсдэл, эмзэг байдлыг бууруулах төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, гамшгаас хамгаалах иж бүрэн болон команд штабын сургууль зохион байгуулах, тухайн цаг үеийн тулгамдсан зорилтыг шийдвэрлэх, түүх судлал, уламжлалт үйл ажиллагааг сэргээн хөгжүүлэх арга хэмжээнд оролцох, санал, зөвлөгөө өгөх,

3.3.5. Онцгой байдлын байгууллагын шинэ, залуу боловсон хүчинд ажлын арга туршлагаасаа зааж сургах, дадлага олгоход мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;

3.3.6.Баг ажлын тайлангаа жилд 2-оос доошгүй удаа Онцгой байдлын ерөнхий газрын даргын зөвлөлд танилцуулна.

*Тав. Бусад зүйл*

4.1. Багийн үйл ажиллагаанд шаардагдах санхүүжилтийг Онцгой байдлын ерөнхий газрын ахмадын сангаас шийдвэрлэнэ. Шаардлагатай тохиолдолд тухайн чиглэлээр хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн хүрээнд санхүүжилтийг шийдвэрлэж болно.

4.2. Энэхүү журамд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Багийн гишүүдийн санал болгосноор Онцгой байдлын ерөнхий газрын даргын зөвлөлийн хуралдаанаар шийдвэрлэнэ.

4.3. Баг нь ахмад мэргэжилтнүүдийн санал бодлыг сонсож, шаардлагатай тохиолдолд үйл ажиллагаандаа тусгана.

4.4.Онцгой байдлын байгууллагын удирдлага, нэгжүүд Багийг шаардлагатай баримт бичиг, мэдээллээр хангаж, үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

4.5. Энэхүү журмын хэрэгжилтэд Захиргааны удирдлагын асуудал хариуцсан нэгж, Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх Ахмадын хороо хяналт тавина.

-----oOo-----